



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 31 өдөр

Дугаар А/214

Бор-Өндөр сум

Төрийн байгууллагын үйл ажиллагаанд
хяналт шинжилгээ хийх, ажлын
үр дүнг үнэлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 59 дүгээр зүйлийн 59.1.20 дахь заалт, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх хэсэг, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралт, Аймгийн Засаг даргын 2021 оны А/105 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төрийн байгууллагын үйл ажиллагаанд 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн хооронд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг үнэлэх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Ц.Жаргалсайхан

Нарийн бичгийн дарга:

Ц.Эсүжин

Гишүүд:

Э.Түвшинсайхан

Б.Оюунтуяа

Ц.Баттуяа

Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн

Нийгмийн бодлогын мэргэжилтэн

Санхүүгийн албаны дарга

Төсөв, төрийн сан хариуцсан мэргэжилтэн

Архив, бичиг хэргийн эрхлэгч

2.Төрийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг үнэлэх удирдамжийг хавсралтаар баталсугай.

3.Удирдамжийн дагуу холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг илтгэх хуудсаар сумын Засаг даргад 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн дотор танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Ц.Жаргалсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.АДЪЯАБИЛЭГТ

БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙХ, АЖЛЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ АЖЛЫН
УДИРДАМЖ

2024 оны 10 дугаар сарын 31

Нэг. Шалгалтын зорилго:

Аймгийн Засаг даргын 2021 оны А/105 дугаар захирамжаар баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ үнэлгээ хийх, нийтлэг журам"-ыг хэрэгжүүлэх аргачлалын дагуу бодлогын баримт бичгийн төлөвлөлтөд хяналт шинжилгээ хийж, зөвлөгөө өгөх, төсвийн байгууллагын ажлын үйл ажиллагаа, санхүүгийн ил тод байдал, хууль тогтоомжийн хэрэгжилт ямар түвшин байгаад үнэлэлт дүгнэлт өгч, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авахад оршино.

Хоёр. Хяналт шалгалтын ажлын үндсэн чиглэл

- Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн төлөвлөлт хэрэгжилт
- Бодлогын баримт бичгийн төлөвлөлт, хэрэгжилт
- Аймгийн Засаг даргын Байгууллагын үйлчилгээний стандартын загвар батлах тухай 2021 оны А/11, Журам батлах тухай, А/168 Хяналтын хуудас хэрэглэх журам батлах тухай А/340 дугаартай захирамжийн хэрэгжилт
- Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хагас жилийн тайлан, албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хагас жилийн тайлан, үнэлгээний хуудас
- Байгууллагад ирсэн өргөдөл гомдлын бүртгэл, тэдгээрийн шийдвэрлэлт
- Шилэн дансны мэдээлэл (шилэн дансны мэдээлэл, мэдээллийг тогтмол шинэчилдэг эсэх)
- Төрийн албан хаагчийн сургалт ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт
- Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичиг, эцэг эхийн зөвлөлийн төлөвлөгөө, Хүүхэд хамгааллын багийн төлөвлөгөө, хагас жилийн тайлан, эрсдлийн үнэлгээний дагуу хийсэн ажлын тайлан
- Хугацаатай албан бичгийн шийдвэрлэлт, албан бичиг төлөвлөлтийн стандарт
- <https://erp.e-mongolia.mn/> системийн ашиглалт
- Архив, албан хэрэг хөтлөлт
- Бараа материалын тайлан, харилцахын баримт
- 2024 оны хагас жилээр өгсөн зөвлөмжийн дагуу гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө гаргаж хэрэгжилтийг хангасан эсэх

Гурав. Хугацаа

Хяналт шинжилгээ үнэлгээг 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн дотор явуулна.

Дөрөв. Тайлагнах журам

Хяналт шинжилгээ үнэлгээний тайланг мэдээг ажлын 7 хоногийн дотор Засаг даргад танилцуулна.